

АЖЛЫН ДААЛГАВАР

Монгол Улс: Ухаалаг засаг төсөл

Төслийн дугаар: 5483-MN

Зөвлөх үйлчилгээний нэр: Бизнес аналитик, загварчлалын мэргэжилтэн

Лавлах дугаар: 1.2.2 а

Танилцуулга

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ) мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйл ажиллагаанд оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, ил тод, үр ашигтай болгох зорилгоор Ухаалаг засаг төслийг хэрэгжүүлж байна.

Уг төслийн хүрээнд ЗГХЭГ нь бизнес-аналитикийн программ (BA) нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд Бизнес-аналитикийн системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Бизнес аналитик, загварчлалын мэргэжилтнийг авч ажиллуулахаар төлөвлөж байна.

Бизнес-аналитикийн систем гэж Засгийн газрын үйл ажиллагаа болон төрийн өгөгдөл болон статистикийн аргачлалд үндэслэн гарсан түүний гүйцэтгэлийг шинэ өнцгөөс харах, ойлгох чадавхыг хөгжүүлэхэд чиглэгдсэн ур чадвар, технологи, аппликейшн, процесс, практикийн бүрдэл юм. Аналитикийн загварчлал, тайлбарлах болон таамаглах загварчлалын тоон шинжилгээ, баримтад тулгуурласан менежментийг бизнес-аналитикийн системд түлхүү ашиглаж, Засгийн газрын шийдвэр гаргах үйл ажиллагааг чиглүүлнэ.

Зорилго

Зөвлөх үйлчилгээний зорилго нь ЗГХЭГ-т Бизнес-аналитикийн системийг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Дэмжлэг үзүүлэхдээ тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа ажлын хэргийн (transactional) болон нийгмийн (social) өгөгдөлд шинжилгээ хийх боломжийг Монгол Улсын Засгийн газарт олгох, бодлогын боловсруулахад тухай бүр асуудлын тухай нарийвчилсан ойлголт өгөх, үйлчилгээг сайжруулах, нөөцийг оновчтой зохион байгуулах ажиллагааг сайжруулан хөгжүүлэх

ажлыг гүйцэтгэнэ.

Ажлын цар хүрээ, гүйцэтгэх үүрэг

Бизнес аналитик, загварчлалын мэргэжилтэн нь Бизнес аналитик, мэдээллийн технологийн мэргэжилтэнтэй хамтран БА-ийн системийн шинжилгээ хийх, БА-ийн системийн болон өгөгдлийн загварууд боловсруулах бөгөөд дараах үндсэн ажил үүргийг гүйцэтгэнэ:

- өгөгдлийн аналитик шинжилгээ, тайлангийн архитектур боловсруулж хэрэгжүүлэх, өгөгдлийн удирдлага, чанарын хяналт, холбогдох бизнесийн болон аналитикийн үйл ажиллагааны загваруудыг боловсруулах;
- өгөгдөлд дүн шинжилгээ хийх, хөрвүүлэх, таамаглал, аналитик шийдлүүд боловсруулах замаар тохирох статистикийн арга техник, аргачлалыг боловсруулж ашиглах;
- үнэ цэнийн шинжилгээ хийх буюу тайлбарлах замаар Засгийн газарт үнэ цэнэ бий болгох боломжуудыг бий болгох;
- өгөгдөл цуглуулахаас эхлээд дүн шинжилгээ, техник загварчлал, туршилт, ашиглалтад оруулах хүртэл бизнесийн тандалт судалгаа, дүн шинжилгээний шийдэл боловсруулах, хэрэгжүүлэх бүхий л үйл явцад оролцох;
- шинэ, хуучин/одоогийн/ өгөгдлийн цуглуулж бэлтгэн дээд түвшний өгөгдлийн менежмент, дүн шинжилгээ, дүрслэлийн мэдлэгийн эх үүсвэртэй холбох замаар ЗГХЭГ-ын үйл ажиллагаанаас гарч буй бүтээгдэхүүн, эцсийн үр дүнг ойлгоход дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Дараах нарийвчилсан ажил үүргийг гүйцэтгэх ба үүгээр хязгаарлагдахгүй:

- a. Засгийн газрын стратегийн хэрэгцээ, өсөлтийн төлөвлөгөөг ойлгож, дүн шинжилгээ хийх;
- b. Сонгосон хэрэгсэл, арга техникийг ашиглан өгөгдөлд дүн шинжилгээ хийж Засгийн газрын шийдвэрийг мэдээллээр хангах;
- c. Дата анализийн өгөгдлийн эх сурвалж, хэрэгсэл, арга техникийг тодорхойлох;
- d. Боломжит өгөгдөл, өгөгдлийн хязгаарлалт зэрэг өгөгдөл нөлөөлөх тохиромжтой хувьсагчийг тодорхойлох;
- e. Бусад эх сурвалжийн тайланг гаргахад шаардлагатай тулгамдаж буй асуудал, өгөгдлийн хэрэгцээ, шаардлагуудыг тодорхойлох;
- f. Иргэдэд илүү сайн үйлчилж, шийдвэр гаргах үйл явцыг сайжруулах засгийн газрын эрэлт хэрэгцээнд тулгуурласан БА-ийн шинэ шийдлийг боловсруулах;
- g. Өгөгдөл цуглуулах, өгөгдлийг шинжлэх бодлого, журам боловсруулах;

- h. Бизнесийн тандалт судалгаа /Бизнес-интележенс/ боловсруулах;
- i. Засгийн газрын иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах системийн эргэх хариуцлагыг сайжруулах арга хэмжээ боловсруулах;
- j. Дүн шинжилгээний үр дүнг тайлангийн зохих загварын дагуу танилцуулах;
- k. Шийдвэр гаргагч, удирдлагуудад зориулсан бизнесийн тандалт судалгаа/интележенс/, дүн шинжилгээний тайлан бэлтгэж танилцуулдаг болох;
- l. Мэдээлэл, чиг хандлагыг цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх замаар техникийн тайлан боловсруулах;
- m. Цуглуулсан асгийн газрын өгөгдлийг хянан баталгаажуулах;
- n. Мета датад харгалзах концепци (conceptual), логик (logical), физик (physical) өгөгдлийг сайжруулах;
- o. Дата загварын тогтвортой хэрэглээг бий болгох зорилгоор стандарт нэршил, кодчиллын сайн жишиг туршлагыг боловсруулах;
- p. Логик болон физик дата загваруудыг оновчтой болгогн шинэчлэж, шинэ болон одоогийн төсөл арга хэмжээг дэмжих;
- q. Эцсийн хэрэглэгчид, засгийн газрын ажилтнуудад зориулсан мэргэжлийн болон техникийн сургалт, семинаруудыг удирдан зохион байгуулж, мэргэжлийн ном, гарын авлагаар хангах, төрийн байгууллагуудын хэмжээнд БА хэрэглэгчдийн сүлжээ бий болгох;
- r. ЗГХЭГ-ийн Мэдээллийн технологийн хэлтэс, Бизнес аналитик, МТ-ийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж өгөгдлийн мэргэжилтэнтэй хамтран өгөгдлийн стратеги хэрэгжүүлэх, дата урсгалыг бий болгох, концепци дата загварыг боловсруулах.

Хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн:

1. БА хэрэглэх тохиолдол, засгийн газрын өгөгдлийн загварыг боловсруулж, зохих арга техник, хэрэгслийг сонгон тогтоогдсон хэрэглээ, хамрах хүрээнд Засгийн газрын БА-ийн систем бий болгосон байх;
2. Өгөгдлийн эх үүсвэрүүдийг өгөгдлийн бэлэн байдал, хязгаарлалтын хамт тогтоож БА-ийн системд зориулсан мэдээллийн нэгдсэн систем боловсруулсан байх;
3. Концепци, логик болон физик загваруудыг танилцуулж, тэргүүн туршлагыг нэвтрүүлсэн байх;
4. Бизнесийн тандалт судалгааны загвар боловсруулж нэвтрүүлсэн байх;
5. Өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх бодлого, журам боловсруулсан байх;
6. Шийдвэр гаргагчид, удирдлагуудад зориулсан бизнесийн тандалт, дүн шинжилгээний баримт бичгийн тайлан гаргасан байх;

7. БА-ийн системийн Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд, хэмжих аргыг тогтоосон байх;
8. Бодлого, шийдвэр гаргах түвшинд БА-н системийн хэрэглээг нэвтрүүлсэн байх;
9. БА-ийн системийн гарын авлага гаргасан байх;
10. Хэрэглэгчдэд зориулсан сургалт хийсэн байх.

Зөвлөхийн тавигдах шаардлага, сонгон шалгаруулах шалгуур:

Амжилттай өргөдөл гаргагчид нь мэдээллийн технологи, бизнесийн аналитик, статистик, системийн шинжилгээний чиглэлээр мэргэшсэн байна. Мөн засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагааны талаар ойлголт сайтай, Засгийн газрын бизнесийн үйл явцын талаарх мэдлэг, туршлага сайтай байх нь чухал. Засгийн газрын дижитал үйлчилгээ, иргэдтэй харилцах механизмуудын чиглэлээр өмнө нь ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Бизнес аналитик, загварчлалын зөвлөхөд тавигдах шаардлага :

- Компьютерын шинжлэх ухаан, мэдээллийн менежмент/технологи, статистик, эсвэл холбогдох чиглэлээр бакалаврын зэргээс доошгүй боловсролтой;
- Үндэсний эсвэл олон улсын түвшинд төсөл удирдаж ажиллах чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай;
- Бизнесийн буюу үйл ажиллагааны загварчлал, Өгөгдлийн сан, өгөгдлийн загварчлал, тухайлбал Oracle, Microsoft SQL Server, MySQL-н ойлголт мэдлэгтэй;
- Хяналтын самбар (dashboards), инфографик танилцуулгын загвар боловсруулах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай;
- Өгөгдлийн дүн шинжилгээ, түүний дотор таамаглал боловсруулах, харьцуулсан шинжилгээ, хүн ам зүй, газар зүйн шинжилгээ, түүхэн чиг хандлагын шинжилгээ, сценар төлөвлөлт, Дельфи техник, статистикийн үндсэн тооцооллын (голч, дундаж, хэвийн тархалт гэх мэт) чиглэлээр ажиллаж байсан туршлагатай;
- Бизнесийн шинжилгээний хэрэгслүүд, статистикийн багцууд, тухайлбал SPSS, SAS, Tableau, бизнесийн тандалт, тайлангийн хэрэгсэл, RevoScaleR гэх мэт R-т суурилсан хэрэгслүүдийг ашиглаж байсан туршлагатай;
- Англи, Монгол хэлээр харилцах (бичгийн, ярианы, илтгэлийн) ур чадвартай;
- Иргэдтэй харилцах төвийн үйл ажиллагаанд бизнесийн аналитик хийж байсан туршлагатай бол давуу тал болно;

Ажиллах хугацаа, зохион байгуулалт:

Энэхүү ажлын даалгаварт 12 хүн/сар зарцуулахаар төлөвлөж байна. Ажлын хангалттай гүйцэтгэл, ажлын хэрэгцээ шаардлагаас хамаарч гэрээг шинэчлэх боломжтой. Уг ажлыг Монгол улсад хийж гүйцэтгэнэ. Бизнесийн аналитик, загварчлалын мэргэжилтэн нь ЗГХЭГ-тай гэрээ байгуулж, ЗГХЭГ-ын Бизнесийн аналитик, МТ-ийн мэргэжилтэн болон бусад холбогдох багтай нягт хамтран ажиллана.